

Анхны их наядтан

SpaceX компанийн IPO-ийн дараа Илон Маск түүхэн дэх анхны их наядтан болжээ.



Guest

👁️ 1,566 · 4 мин уншина

Нийтлэл оруулмагц авья



SpaceX компанийн IPO-ийн дараа Илон Маск түүхэн дэх анхны их наядтан болжээ. Хувьцаагаа олон нийтэд санал болгохоос өмнө түүний хөрөнгө ойролцоогоор 820 тэрбум доллар байсан бол одоо анх удаа нэг их наяд ам. долларын босгыг давлаа. Энэ нь сайн уу, муу юу гэдэг нь хэнээс асууж байгаагаас шалтгаална.

Юуны өмнө мэдвэл зохих зарим баримтыг дурдъя. Зөвлөлт Холбоот Улс болон Зүүн Европт социализм нуран унаж, Хятадад Маогийн үеийн социализм төгсгөл болсны дараа дэлхийн тэрбумтнуудын тоо эрс өссөн. 2000 оны эхэнд дэлхий даяар 470 орчим тэрбумтан байсан бол өнөөдөр энэ тоо ойролцоогоор 3,400 хүрч, долоо дахин нэмэгджээ. 2000 онд тэдний нийт хөрөнгө 898 тэрбум ам. доллар байсан бол өнөөдөр 20 их наяд ам. долларт хүрсэн байна. Инфляцыг



Хуваалцах

Капитализмын эсрэг үзэлтнүүд энэ өсөлтийг уур уцаартай зүхдэг. Ядуурал байсаар байгаа дэлхийд ийм их баялаг цөөн хэдхэн гарт төвлөрч буйг тэд дуу шуу болгон шударга бус үзэгдэл гэж үздэг. Гэвч энэ хугацаанд ядуурал эрс буурсан юм. Туйлын ядууралд амьдарч буй хүмүүсийн эзлэх хувь 2000 онд 29.3 хувь байсан бол өнөөдөр ойролцоогоор 10 хувь болж буурсан (Дэлхийн банкны өмнөх аргачлалаар тооцвол бүр 6.5 хувь орчим байхаар байв).

Капитализмын эсрэг үзэлтнүүдийн баримталдаг “тэг нийлбэрт сэтгэлгээ”-гээр бол ийм зүйл байж боломгүй үзэгдэл юм. Хэрэв туйлын ядуу хүмүүсийн тоо ийм ихээр буурсан бол хэт баячуудын өсөн нэмэгдэж буй хөрөнгө хаанаас бий болсон байх вэ? Эдгээр тоон үзүүлэлтүүд нь капитализмын эсрэг үзэлтнүүдийн үндсэн таамаглал болох “баячууд зөвхөн ядуусын зардлаар баяжсан” гэх ойлголт худал болохыг харуулж байна. Үнэндээ тэрбумтнуудын тоо өссөн болон туйлын ядуурал буурсан хоёрын нийтлэг шалтгаан нь **эдийн засгийн өсөлт** юм.

Элон Маскийн түүх нь “Америк мөрөөдөл” амьд хэвээр байгааг харуулдаг. Тэр Өмнөд Африкаас цагаачлан Хойд Америкт ирж, дараа нь АНУ-д суурьшин, Tesla болон SpaceX-ийг гайхамшигтай амжилтад хүргэсэн. Тэр ганцаараа биш. Sergey Brin багадаа гэр бүлийн хамт Зөвлөлт Холбоот Улсаас АНУ-д ирж, Larry Page-тэй хамтран Google-ийг байгуулсан. Jensen Huang Тайваньд төрж, хүүхэд байхдаа цагаачлан ирээд Nvidia-г дэлхийн хамгийн үнэ цэнтэй компаниудын нэг болгож чадсан.

Эдгээр түүхүүд өнөөгийн их хөрөнгүүд ихэвчлэн өвлөгдсөн



өөрийн хүчээр хөрөнгөжсөн тэрбумтнуудын хувь урьд өмнөхөөсөө эрс нэмэгдсэн. Forbes-ийн мэдээллээр Америкийн тэрбумтнуудын 73 орчим хувь нь хөрөнгөө өөрсдөө бүтээсэн бол ердөө 27 орчим хувь нь голчлон өвлөсөн хөрөнгөтэй байна.

Элон Маск шиг хүмүүсийг юу хөдөлгөдөг вэ? Тэрээр 2016 оны зургаадугаар сард болсон нэгэн бага хурал дээр өөрийн урам зоригийг ийн тайлбарласан байдаг:

“Дэлхий дээр маш олон сөрөг зүйл бий. Аймшигтай зүйлс үргэлж тохиолдож байдаг. Шийдвэрлэх шаардлагатай олон асуудал, хүнийг шаналгадаг зүйлс бий. Гэхдээ амьдрал зөвхөн нэг таагүй асуудлыг нөгөөгөөр нь сольж шийдвэрлэх тухай байж болохгүй. Үүнээс илүү зүйл хэрэгтэй. Танд урам өгдөг, өглөө сэрэхэд баярлуулдаг, хүн төрөлхтний нэг хэсэг байхыг үнэ цэнтэй болгодог зүйлс хэрэгтэй. Одоо бид одод руу тэмүүлсэн соёл иргэншил болж, сансар огторгуйд гарч, хүний ухамсрын хүрээ, цар хүрээг тэлэх цаг болсон. Энэ нь надад үнэхээр гайхамшигтай санагддаг. Энэ нь намайг амьд байгаадаа баярлуулах шалтгаан болдог.”

Гуч хүрэхгүй жилийн өмнө Элон Маск хуучин PayPal-ын хамтрагчдынхаа хамт усан сангийн хажууд сууж, Оросын пуужингийн хөдөлгүүрийн хуучирсан гарын авлагыг сөхөн судалж байжээ. Найз нь түүний төлөвлөгөөг асуухад Маск:

“Би Ангараг гарагийг байлдан эзлэх гэж байна. Миний амьдралын зорилго бол хүн төрөлхтнийг олон гарагт оршин тогтнодог соёл иргэншил болгох.” гэж хариулсан байна. Харин хамтрагч нь: “Хөөе, чи бүр галзуу юм байна!” гэж дуу



Өнөөдөр Элон Маск дэлхийн сансрын салбарт ноёрхож байна. Өнгөрсөн жил хийгдсэн тойрог замын 324 хөөргөлтийн 165-ыг SpaceX дангаараа гүйцэтгэсэн. Хэрэв SpaceX гэж улс орон байсан бол 88 хөөргөлт хийсэн Хятадыг хол ардаа орхиж, дэлхийд нэгдүгээрт орох байв. Одоогоор дэлхийн тойрог замд ажиллаж буй ойролцоогоор 15,000 хиймэл дагуулын 10,000 орчим нь Starlink-ийнх юм. Элон Маск сансрын хөөргөлтийн зардлыг Space Shuttle-ийн үеийнхтэй харьцуулахад ойролцоогоор 95 хувиар бууруулж, дахин ашиглах боломжтой анхны тойрог замын пуужинг хөгжүүлсэн бөгөөд энэ амжилтад одоог хүртэл ямар ч төрийн сансрын агентлаг хүрч чадаагүй байна.

Шүүмжлэгчид Элон Маскийн хөрөнгө голчлон төрийн татаасаас үүдэлтэй гэж байнга маргадаг бөгөөд ихэвчлэн 37 тэрбум долларын дэмжлэг авсан гэсэн тоог иш татдаг. Гэвч энэ нь үндэслэлгүй юм. Тэд SpaceX-ийн үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг тэгж мушгин гуйвуулдаг. NASA сансрын хөлгийн хөтөлбөрөө зогсоож, олон улсын сансрын станцад хүрэх боломжгүй болсон үедээ “эцсийн найдвар” гэж хэмээн шийдвэр гаргаж, SpaceX-д хандсан. Элон Маск NASA-д тэдний зарцуулдгаас хавьгүй их мөнгийг нь хэмнэж өгсөн. Тэр ч байтугай 37 тэрбум долларыг бүхэлд нь зөвшөөрсөн ч энэ нь түүний өнөөгийн хөрөнгийн 4 хүрэхгүй хувийг л эзэлнэ.

Райнер Цительманн (Rainer Zitelmann) нь “*New Space Capitalism*” номын зохиогч юм.

